



Захиргааны хэм хэмжээний
актын улсын нэгдсэн санд
2018 оны 05 сарын 01-ны
өдрийн 389/ дугаарт Суртал.

**МОНГОЛ УЛСЫН БОЛОВСРОЛ,
СОЁЛ, ШИНЖЛЭХ УХААН, СПОРТЫН
САЙДЫН ТУШААЛ**

2018 оны 04 сарын 03 өдөр

Дугаар А/167

Улаанбаатар хот

Журам батлах тухай

Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 24.2 дахь заалт, Биеийн тамир, спортын тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.1.8 дах заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:


1. “Үндэсний шигшээ багийг бүрдүүлэх, спортын төрлийг сонгох, санхүүжүүлэх журам”-ыг нэгдүгээр, сонгон шалгаруулах зөвлөлийн бүрэлдэхүүнийг хоёрдугаар хавсралтаар тус тус баталсугай.
2. Үндэсний шигшээ багийг бүрдүүлэх, спортын төрлийг сонгох, санхүүжүүлэх журмын хэрэгжилтэд хяналт тавьж, удирдлага зохион байгуулалтаар хангаж ажиллахыг Биеийн тамир, спортын бодлогын газар /С.Чинбат/-т даалгасугай.
3. Энэ тушаал батлагдсантай холбогдуулан Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын сайдын 2016 оны “Журам батлах тухай” 131 дүгээр тушаалыг хүчингүй болсонд тооцсугай.

САЙД



Ц.ЦОГЗОЛМАА

Боловсрол, соёл, шинжлэх ухаан,
спортын сайдын 2018 оны 04 дүгээр
сарын 03 ны өдрийн 1/07 тоот тушаалын
нэгдүгээр хавсралт



ҮНДЭСНИЙ ШИГШЭЭ БАГИЙГ БҮРДҮҮЛЭХ, СПОРТЫН ТӨРЛИЙГ СОНГОХ, САНХҮҮЖҮҮЛЭХ ЖУРАМ

Нэг. Нийтлэг үндэслэл

1.1. Улсын төсвөөс санхүүжүүлэх Үндэсний шигшээ багийг бүрдүүлэх спортын төрлийг сонгох, тамирчин, дасгалжуулагчийг сонгон шалгаруулахад тавигдах үндсэн шаардлага, тухайн спортын төрлийн үндэсний шигшээ багийн үйл ажиллагааг хариуцан зохион байгуулах спортын холбоодод тавигдах шаардлага, улсын төсвийн санхүүжилтээр дэмжлэг үзүүлэх ажил үйлчилгээтэй холбоотой харилцааг энэхүү журмаар зохицуулна.

1.2. Үндэсний шигшээ баг нь Олон Улсын Олимпийн Хорооны ивээл дор явагддаг тив, дэлхийн наадам, тэмцээнд Монгол Улсыг төлөөлж оролцоно.

1.3. Өсвөр үе, залуучууд, оюутан, паралимпийн спортын үндэсний шигшээ багийн үйл ажиллагаатай холбоотой харилцаанд энэ журмыг баримтлана.

1.4. Энэ журмын хүрээнд Биеийн тамир, спортын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага, тухайн спортын холбооны хооронд байгуулах гэрээ нь тухайн төсвийн жилд хэрэгжих бөгөөд гэрээ дүгнэсний үндсэн дээр нэг жилээр сунгагдана.

Хоёр. Спортын төрлийг сонгох

2.1. Үндэсний шигшээ багийг бүрдүүлэх спортын төрлийг сонгох үйл ажиллагааг Биеийн тамир, спортын асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүний шийдвэрээр байгуулсан Сонгон шалгаруулах зөвлөл /цаашид Зөвлөл гэх/ хэрэгжүүлнэ.

2.2. Зөвлөлийг Биеийн тамир, спортын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын Биеийн тамир, спортын бодлогын асуудал хариуцсан нэгжийн дарга удирдана.

2.3. Зөвлөлийн бүрэлдэхүүнд нь Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын яам, Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг Биеийн тамир, спортын газар, Монголын үндэсний олимпийн хороо, Монголын үндэсний паралимпийн хорооны төлөөллийг оролцуулна.

2.4. Зөвлөлийн үйл ажиллагааны үндсэн хэлбэр нь хуралдаан байна.

14 нэгж - 1/07 тоот

2.5. Зөвлөл нь хурлаар хэлэлцсэн асуудлаа хуралд оролцож буй гишүүдийн олонхын саналаар шийдвэрлэнэ.

2.6. Хуралдааны тэмдэглэлд хурал даргалагч, тэмдэглэл хөтлөгч гарын үсэг зурснаар баталгаажна.

2.7. Зөвлөл нь үйл ажиллагаандаа шударга бус өрсөлдөөн, ашиг сонирхлын зөрчил, авилга хээл хахуулиас ангид байх зарчмыг баримтлана.

2.8. Улсын төсвөөс санхүүгийн дэмжлэг үзүүлэх спортын төрлийг сонгохдоо дараах ерөнхий шалгуурыг харгалзан үзнэ. Үүнд:

2.8.1. тухайн спортын төрлөөр олимп, паралимпийн наадам, дэлхийн аварга шалгаруулах тэмцээнд сүүлийн гурван жил медальт болон шагналт байранд шалгарсан байдал

2.8.2. тухайн спортын төрлөөр Ази тивийн наадам, тивийн аварга шалгаруулах тэмцээнд медальт болон шагналт байранд шалгарсан байдал,

2.8.3. тухайн спортын төрлөөр улсын хэмжээнд зохион байгуулагддаг тэмцээний тоо, хичээллэгчдийн тоог харгалзах

2.8.4. материаллаг бааз, хүний нөөцийн хүрэлцээ хангамж,

2.8.5. спортын холбоо ажлын албатай байх /холбооны ерөнхийлөгч, ерөнхий нарийн бичгийн дарга, ажлын албаны ажилтан нь Үндэсний шигшээ багийн дасгалжуулагчийн ажлыг хавсран хийхгүй байх/

2.9. Олон улсад бүртгэлтэй спортын холбоодын хөгжүүлж байгаа нийт спортын төрлүүдийн жагсаалт мэдээлэлд үндэслэн Зөвлөл нь журмын 2.8.1-2.8.5, 3.1.1-3.1.10 дахь хэсэгт заасан шалгуур, үзүүлэлтийн дагуу Үндэсний шигшээ багийг бүрдүүлэх спортын төрлийг сонгох дүгнэлт гарган, биеийн тамир, спортын асуудал хариуцсан Засгийн газрын гишүүнд танилцуулна.

2.10. Спортын холбооны зохион байгуулсан сонгон шалгаруулалттай холбоотой аливаа маргааныг зохих журмын дагуу шийдвэрлүүлнэ.

2.11. Зөвлөлийн ажлын албаны гүйцэтгэх чиг үүргийг Биеийн тамир, спортын асуудал эрхэлсэн төрийн төв захиргааны байгууллагын биеийн тамир, спортын асуудал хариуцсан нэгж хэрэгжүүлнэ.

2.12. Биеийн тамир, спортын асуудал эрхэлсэн сайдын тушаалаар Зөвлөлийн сонгосон спортын төрлийг баталгаажуулна.

2.13. Улсын төсвөөс санхүүгийн дэмжлэг авах үндэсний шигшээ багийг бүрдүүлэх спортын төрлийн сонгон шалгаруулалтыг хуанлийн 20-иос доошгүй хоногийн өмнө өдөр тутмын хэвлэл мэдээллийн хэрэгслээр нийтэд зарлана.

2.14. Зарлалд сонгон шалгаруулалтад спортын төрлөө нэр дэвшүүлэхэд

бүрдүүлэх баримт бичиг, бүртгүүлэх хугацаа, бусад шаардлагатай мэдээллийг тусгана.

2.15. Сонгон шалгаруулалтад оролцох спортын холбоод дор дурдсан бичиг баримтыг бүрдүүлэн ирүүлнэ.

2.15.1. нэр дэвшүүлэх тухай холбооны хүсэлт,

2.15.2. олон улсын спортын холбоогоор хүлээн зөвшөөрөгдсөн албан ёсны батламж,

2.15.3. спортын холбооны дүрэм,

2.15.4. “төрийн бус байгууллагын тухай хууль”-ийн 23 дугаар зүйлд заасан тайлангийн хувь, /сүүлийн 2 жилээр/,

2.15.5. журмын 3.1.4, 3.1.5, 3.1.6, 3.1.7, 3.1.8-д заасан дүрэм, бүртгэл мэдээлэл, дүгнэлт,

2.15.6. спортын холбооны үйл ажиллагааны стратеги төлөвлөгөө,

2.15.7. холбооны төсвийн зарцуулалтыг шилэн болгосон байх,

2.16. Спортын холбоодын нэр дэвшүүлэх хүсэлтийг сонгон шалгаруулалтыг зохион байгуулах өдрөөс 5 хоногийн өмнө дуусгавар болгоно.

2.17. Сонгон шалгаруулалтыг зохион байгуулсан өдрөөс хойш ажлын 5 хоногт багтаан дүгнэлтийг танилцуулна.

2.18. Сонгон шалгаруулалттай холбоотой мэдээллийг спортын холбоо, тамирчдад танилцах боломжтойгоор олон нийтэд нээлттэй мэдээлнэ.

Гурав. Спортын холбоонд дэмжлэг үзүүлэхэд тавигдах шаардлага;

3.1. Улсын төсвөөс санхүүгийн дэмжлэг үзүүлэх спортын төрлийн холбоод дараах тусгай шалгуурыг хангасан байна. Үүнд:

3.1.1. Спортын холбоо бүр тухайн жилийн улсын төсвөөс санхүүжүүлэх зардлын 1/4-тэй тэнцэх хэмжээний эрсдэлийн сантай байх,

3.1.2. Авлигын эсрэг хуулийн 4.1.5 дахь заалтын дагуу спортын холбооны удирдах албан тушаалтан Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 23.3-т заасны дагуу ХАСХОМ гаргасан байх, гаргах үүрэг хүлээх болохыг мэдсэн байх;

3.1.3. Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 3.1.5-д заасны дагуу спортын холбооны удирдах албан тушаалтнууд хамаарал бүхий этгээд биш байх,

3.1.4. Улсын бүртгэлийн гэрчилгээ, шинэчилсэн бүртгэлд хамрагдсан

байх,

3.1.5. Харьяа аймаг, дүүргийн санхүү, татварын албанд бүртгэлтэй байх, арилжааны банкинд өөрийн данстай байх, нягтлан бодогч ажиллуулах,

3.1.6. Холбооны дүрмийн дагуу техникийн, ёс зүйн, шүүгч, дасгалжуулагчийн зөвлөлтэй байх, /УЗ-өөр баталгаажсан байх/

3.1.7. Санхүүгийн үйл ажиллагаа, тайланд аудитын үнэлгээ хийлгэдэг байх,

3.1.8. Татварын албанд өргүй байх,

3.1.9. Байгуулсан гэрээний хэрэгжилт, санхүүжилттэй холбоотой тайлан, баримтуудыг цаг тухайд нь Биеийн тамир, спортын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагад гаргаж өгөх, тайлбар хүргүүлэх;

3.1.10. Үндэсний шигшээ багийн тамирчин, дасгалжуулагчдын ур чадвар, дотоодын өрсөлдөөнийг нэмэгдүүлэх зорилгоор насанд хүрэгчид, залуучууд, өсвөр үеийн насны ангилалд тэмцээн зохион байгуулдаг байх,

3.2. Улсын төсвөөс үндэсний шигшээ багт дараах чиглэлээр санхүүгийн дэмжлэгийг үзүүлнэ.

3.2.1. Бэлтгэл хийх заал танхимаар хангах,

3.2.2. Бэлтгэлийн хувцсаар хангах

3.2.3. Тэмцээний хувцсаар хангах

3.2.4. Спортын хэрэглэл материалаар хангах,

3.2.5. Эм витамин, тариа, боолт хэрэгслээр хангах,

3.2.6. Нэмэлт бүтээгдэхүүн, уургаар хангах

3.2.7. Эмнэлэгийн үзлэг, оношилгоонд хамруулах

3.2.8. Сургалт, судалгаанд хамруулах

3.2.9. Даатгалд хамруулах

3.2.10. Дотоодын бэлтгэл цугларалтыг санхүүжүүлэх,

3.2.11. Гадаадын бэлтгэл цугларалтыг санхүүжүүлэх,

3.2.12. Олон улс, тив, дэлхийн тэмцээн, наадамд оролцох зардлыг санхүүжүүлэх

3.2.13. Хууль тогтоомжийн дагуу баталсан албан тушаалын ангилал, зэрэглэлийн дагуу тогтоосон цалин, хөлс олгох зардал

3.3. Энэ журмын 3.2 дугаар зүйлийн 3.2.1-3.2.10 дахь заалтад заасан шаардлагыг хангасан байдлаас хамаарч спортын холбоонд улсын төсвөөс

дэмжлэг үзүүлэх зардлын зүйлийг гэрээнд тусган хэрэгжүүлнэ.

3.4. Энэ журмын 3.2 дугаар зүйлийн 3.2.4-3.2.8 дахь заалтад заасан ажил үйлчилгээ, зардлын төсвийн хэмжээг батлан, төсвийн жилийн эхэнд Биеийн тамир, спортын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага холбогдох хууль, энэ журмын дагуу гэрээ байгуулан санхүүжүүлнэ.

3.5. Анх удаа сонгогдон улсын төсвөөс дэмжлэг авах спортын холбоонд журмын 3.2.2, 3.2.3 дахь заалтад хамаарах зардлыг эхний жил олгоно.

3.6. Тухайн жилийн гэрээг дүгнэн, тайланг хэлэлцсэний үндсэн дээр хангалттай үнэлэгдсэн спортын холбоонд журмын дагуу олгох зардлын санхүүжилтийг нэмэгдүүлж болно.

Дөрөв. Үндэсний шигшээ багийн тамирчин, дасгалжуулагчийн сонгон шалгаруулалтад тавигдах үндсэн шалгуур:

4.1. Спортын холбоо Үндэсний шигшээ багийн дасгалжуулагч, тамирчдыг сонгон шалгаруулахдаа дараах зарчмыг баримтлана.

4.1.1. шалгаруулалтад оролцогчдын оролцоог тэгш хангасан байх,

4.1.2. шударга өрсөлдөөн, ил тод байдлыг баримтлах,

4.1.3. ялгаварлан гадуурхал, ашиг сонирхлын зөрчлөөс ангид байх,

4.1.4. дасгалжуулагч, тамирчны амжилт, ур чадварыг бодитоор үнэлэх,

4.1.5. дасгалжуулагчийн сонгон шалгаруулалтын шалгалтуудыг мэргэжлийн байгууллагуудтай хамтран зохион байгуулах.

4.2. Үндэсний шигшээ багийн дасгалжуулагчийг сонгон шалгаруулахдаа дараах үндсэн шалгуурыг хангасан эсэхийг харгалзана.

4.2.1. биеийн тамир, спортын их, дээд сургууль төгссөн бакалавр болон түүнээс дээш боловсролтой байх, мэргэшүүлэх сургалтад хамрагдсан байх,

4.2.2. Биеийн тамир, спортын тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.1 хэсэгт заасан журмын дагуу эрх авсан байх,

4.2.3. хувийн ёс зүй, манлайлал, мэргэжлийн ур чадвар, өндөр зэрэглэлийн тамирчидтай ажилласан ажлын туршлага, мэргэшсэн байдлыг харгалзан үзэх,

4.2.4. тухайн дасгалжуулагчийн бэлтгэсэн тамирчдын гаргасан амжилтын өсөлт, бууралт

4.2.5. олон улсын болон үндэсний спортын холбооны дүрэмд дасгалжуулагчид тавигдсан холбогдох шаардлагыг хангасан байх,

4.3. Үндэсний шигшээ багийн бүрэлдэхүүнд багтах тамирчдыг сонгохдоо дараах үндсэн шалгуурыг харгалзана.

4.3.1. ур чадвартай, өндөр амжилт гаргах магадлалтай, бие бялдар, эрүүл мэнд, сэтгэл зүй, бэлтгэлжилтийн түвшинд тавигдах шалгуурт нийцэж байх.

4.3.2. сахилга бат, харилцааны соёл, хариуцлага хүлээх чадвар, ёс зүйн шаардлагад нийцэх эсэх,

4.3.3. тухайн спортын төрлөөр өсвөр үе, залуучууд, насанд хүрэгчдийн улсын аварга шалгаруулах тэмцээн, улсын хэмжээний спортын наадамд медальт байранд шалгарч байсан байх, /сүүлийн 3 жилд/

4.3.4. тив, дэлхийн аварга шалгаруулах тэмцээн, наадамд медальт болон шагналт байранд шалгарч байсан байх, /сүүлийн 3 жилд/

4.4. Үндэсний шигшээ багийн дасгалжуулагч нь журмын 4.2 дугаар зүйлд үндсэн шалгуурыг хангахаас гадна ур чадвар, туршлагын хувьд дараах тусгай шалгуурыг хангасан байна. Үүнд:

4.4.1. Харилцааны өндөр соёлтой, хүний эрх, гэрээ, хууль эрх зүйн талаар зохих мэдлэгтэй байх,

4.4.2. Багаар ажиллах чадвартай, сүүлийн 2 жилийн хугацаанд олон улсын болон үндэсний холбооны дүрмийн дагуу ёс зүй, сахилгын шийтгэл /захиргааны/-гүй байх.

4.4.3. Интернетийн орчинд ажиллах, компьютерийн өргөн хэрэглээний програмийн дундаас дээш шатны мэдэгдэхүүнтэй байх /шалгалтын дүн/

4.4.4. гадаад хэлний зохих түвшний мэдлэг, ярианы чадвартай байх, /шалгалтын дүн/

4.4.5. Сургалт-дасгалжуулалтын төлөвлөлт хийх чадвартай, спортын шинжлэх ухааны онол, спортын анагаах ухааны арга зүйн мэдлэгтэй, өрсөлдөгчийн судалгаа хийх өндөр чадвартай байх,

4.4.6. Допингийн эсрэг үйл ажиллагааны талаар мэдээлэлтэй байх

Тав. Улсын төсвөөс санхүүжилт авсан спортын холбооны санхүүгийн эрх, үүрэг:

5.1. Сонгон шалгаруулалтаар улсын төсвөөс санхүүгийн дэмжлэг авахаар сонгогдсон спортын төрлийн спортын холбоо нь “Биеийн тамир, спортын тухай хууль”-ийн 18.4 дэх хэсэгт зааснаар Биеийн тамир, спортын асуудал эрхэлсэн

төрийн захиргааны байгууллагатай гэрээ байгуулан ажиллана.

5.2. Улсын төсвийн санхүүжилтийг спортын холбоо нь гэрээнд заасан үйл ажиллагаанд зарцуулна.

5.3. Улсын төсвөөс /БТСГ-аас тогтоосон/ батлагдсан цалин, нэмэгдэл, урамшууллыг үндэсний шигшээ багийн албан ёсны бүрэлдэхүүнд олгох,

5.4. Олон улс, тив, дэлхийн аварга шалгаруулах тэмцээн, наадам, гадаадын улс оронд хамтарсан бэлтгэлд оролцох Үндэсний шигшээ багийн тамирчин, дасгалжуулагчийн нислэгийн тийзийг өөрийн сонгосон гэрээт компанитай гэрээ байгуулан захиалах,

5.5. Үндэсний шигшээ багийн тамирчдын дотоодын бэлтгэл цугларалт хийх шаардлага хангасан дотоодын спортын бэлтгэлийн төв, амралтын газрыг сонгон гэрээ байгуулах эрхтэй бөгөөд гэрээ байгуулахдаа Биеийн тамир, спортын асуудал хариуцсан төрийн захиргааны төв байгууллагын харьяаны спортын бэлтгэлийн төвийг нэн тэргүүнд сонгох зарчим баримтлана.

5.6. Гэрээний дагуу олгосон улсын төсвөөс санхүүжилтээс хэмнэгдсэн төсвийг Биеийн тамир, спортын газарт мэдэгдэн зөвшөөрөл авч, гэрээнд нэмэлтээр тусган зөвхөн үндэсний шигшээ багийн албан ёсны бүрэлдэхүүний үйл ажиллагаанд зарцуулна.

5.7. Биеийн тамир, спортын газартай тохиролцон гэрээнд өөрчлөлт оруулан тив, дэлхийн аварга шалгаруулах тэмцээн, наадамд бэлтгэх зорилгоор тодорхой болзол, хугацаатайгаар тухайн жилийн төсөв, санхүүгийн байдалтай уялдуулан Үндэсний шигшээ багийн бүрэлдэхүүнд бүрэлдэхүүн хөдөлгөөний өөрчлөлтийг хийж болно.

5.8. Үндэсний шигшээ багийн гишүүдийн орон тооноос хамаарч тухайн багт дэмжлэг үзүүлэн ажиллах гэрээт эмч, физиотерапист, сэтгэл зүйчийн тоо, тэдний мэдлэг, ур чадварт тавих шаардлага, тодорхой тохиолдолд гэрээт ажилтнуудыг ажиллуулах эсэхийг Биеийн тамир, спортын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагаас тогтоож, гэрээнд тусган улсын төсвөөс олгох санхүүжилтэд багтаан санхүүжүүлж болно.

5.9. Спортын холбоонд улсын төсвөөс үзүүлэх санхүүгийн дэмжлэгийг Биеийн тамир, спортын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад мэдэгдэн Биеийн тамир, спортын газраас дараах тохиолдолд бууруулах, эсхүл түр зогсооно.

5.9.1. тамирчдын амжилт буурсан,

5.9.2. олимпийн эрх авч чадаагүй,

- 5.9.3. улсын төсвийн санхүүжилтийг гэрээний дагуу зарцуулаагүй,
- 5.9.4. биеийн тамир, спортын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагатай байгуулсан гэрээгээр хүлээсэн үүргээ бүхэлд нь буюу хэсэгчлэн биелүүлээгүй,
- 5.9.5. татварын болон нийгмийн даатгал, эрүүл мэндийн даатгалын татвар, шимтгэлийн өр үүсгэсэн,
- 5.9.6. улсын төсвийн санхүүжилтэд хамрагдах үндэсний шигшээ багийн бүрэлдэхүүн хөдөлгөөний мэдээллийг гэрээнд заасан хугацаанд Биеийн тамир, спортын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагад ирүүлээгүй,

5.10. Биеийн тамир, спортын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагын санаачилгаар сонгогдсон спортын төрлийн холбоотой байгуулсан гэрээгээр олгох санхүүжилтийг дараах тохиолдолд шууд зогсоож, Биеийн тамир, спортын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад мэдэгдэнэ.

5.10.1. үндэсний шигшээ багийн тамирчид, дасгалжуулагчид гадаад улс оронд тэмцээн, наадамд оролцох үедээ Монгол Улсын нэр хүндийг унагаасан аливаа үйлдэл гаргаж, олон улсын спортын холбооноос арга хэмжээ авахуулж, үндэсний шигшээ багийн бүрэлдэхүүнийг бүхэлд нь, эсхүл хэсэгчлэн олон улс, тив, дэлхийн чанартай тэмцээн, наадамд оролцох эрхийг хассан,

5.10.2. олон улсын спортын холбооноос үндэсний спортын холбооны эрхийг хассан,

5.10.3. үндэсний шигшээ багийн 2 буюу түүнээс дээш тамирчид допинг хэрэглэсэн нь тогтоогдон олон улсын холбооноос эрхийг хассан, /давтан хэрэглэсэн/

5.11. Энэ журмын 5.7 дахь хэсэгт заасан шийдвэрийг гарсан даруйд Биеийн тамир, спортын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагын цахим хуудсаар олон нийтэд мэдээлнэ.

Боловсрол, соёл, шинжлэх ухаан,
спортын сайдын 2018 оны 04 дүгээр
сарын 03-ны өдрийн 1/167 тоот тушаалын
хоёрдугаар хавсралт



**ҮНДЭСНИЙ ШИГШЭЭ БАГ БҮРДҮҮЛЭХ СПОРТЫН ТӨРЛИЙГ
СОНГОН ШАЛГАРУУЛАХ ЗӨВЛӨЛИЙН БҮРЭЛДЭХҮҮН**

Зөвлөлийн дарга:

Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын
ямны Биеийн тамир, спортын бодлогын
газрын дарга

Гишүүд:

Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг
Биеийн тамир, спортын газрын Спортын
бодлогын хэрэгжилтийн зохицуулалтын
хэлтсийн дарга

Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг
Биеийн тамир, спортын газрын Спортын
анагаах ухаан, эрдэм шинжилгээний
албаны дарга

Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг
Биеийн тамир, спортын газрын Үндэсний
шигшээ багийн албаны дарга

Монголын Үндэсний Олимпын хорооны
дэд ерөнхийлөгч

Монголын Паралимпийн хорооны дэд
ерөнхийлөгч

Нарийн бичгийн дарга:

Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын
ямны Биеийн тамир, спортын бодлогын
газрын Үндэсний шигшээ багийн асуудал
хариуцсан мэргэжилтэн